005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 2,471,885.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 114.0 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 620,743.0 | 423,726.8 | -197,016.2 |
| Авлага | 249,416.5 | 275,339.1 | 25,922.5 |
| Бараа материал | 91,368.3 | 127,236.8 | 35,868.5 |
| Нөөцийн бараа | 89,341.8 | 88,367.0 | -974.8 |
| Үндсэн хөрөнгө | 2,110,570.4 | 2,397,024.6 | 286,454.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | -689,441.0 | -839,809.2 | -150,368.2 |
| **Нийт хөрөнгө** | 2,471,999.1 | 2,471,885.1 | -114.0 |
| Өр төлбөр | 0.0 | 32,154.7 | 32,154.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,471,999.1 | 2,439,730.3 | -32,268.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | 2,471,999.1 | 2,471,885.1 | -114.0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 620,743.0 мянга, эцсийн үлдэгдэл 423,726.8 мянган төгрөг болж 197,016.2 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | | | | |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 620,743.0 | 423,726.8 | (197,016.2) | 100% |
| Орон нутгийн ерөнхий орлого | 480,640.9 | 264,076.7 | (216,564.2) | 62.3% |
| Орон нутгийн хөгжлийн сан | 74,862.3 | 113,156.4 | 38,294.1 | 26.7% |
| Сум хөгжүүлэх сан | 65,239.8 | 46,493.7 | (18,746.1) | 11.0% |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | | | | |
| Хадгаламж | | | | |
| Дүн | 620,743.0 | 423,726.8 | (197,016.2) | 100% |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 62.3 хувь буюу 264,076.7 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бол 26.7 хувь буюу 113,156.4 мянган төгрөг нь сумын ОНХС-ийн, 11.0 хувь буюу 46,493.7 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 264,076.7 мянган төгрөг байснаас 32,193.1 мянган төгрөг нь сумын ЗДТГ, ИТХ-ын оны эцэст буцааж төвлөрүүлсэн төвлөрүүлэх шилжүүлэг, 231,883.6 мянган төгрөг нь орон нутгийн орлого давснаас шалтгаалан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.4.2 Авлага

Оны эхний 249,416.5 мянган төгрөгийн авлага 25,922.5 мянган төгрөгөөр нэмэгдэн оны эцэст 275,339.1 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл / мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 33300 - Татаас санхүүжилтийн авлага | - | 32,154.7 | 32,154.7 | 11.7 |
| 33510 - Байгууллагаас авах авлага | 25,730.3 | 3,500.0 | (22,230.3) | 1.3 |
| 33520 - Хувь хүмүүсээс авах авлага | 90,000.0 | 90,000.0 | - | 32.7 |
| 33612 - Хувь хүмүүст олгосон зээл | 133,686.3 | 149,684.3 | 15,998.1 | 54.4 |
| Дүн | 249,416.5 | 275,339.1 | 25,922.5 | 100.0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 54.4 хувийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хувь хүмүүст олгосон зээл, 32.7 хувийг сумын ЗДТГ-т 2023 онд аймгийн ОНӨГ-ын шийдвэрээр бүртгэсэн моторын авлага, 1.3 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байгаа ба авлагын 11.7 хувь нь сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн өвс, тэжээлийн үнийг орон нутгийн дансанд оны эцэст төвлөрүүлснээс үүссэн авлага эзэлж байна.

*Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

| № | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Үүнээс: 33300 - Татаас санхүүжилтийн авлага | 33510 - Байгууллагаас авах авлага | 33520 - Хувь хүмүүсээс авах авлага | 33612 - Хувь хүмүүст олгосон зээл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ | 112,914.6 | 122,154.7 | 32,154.7 | - | 90,000.0 | - |
| 2 | ОНХС | 2,815.7 | 3,500.0 | - | 3,500.0 | - | - |
| 3 | Хоршоо хөгжүүлэх сан | 133,686.3 | 149,684.3 | - | - | - | 149,684.3 |
| | ДҮН | 249,416.5 | 275,339.1 | 32,154.7 | 3,500.0 | 90,000.0 | 149,684.3 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Оны эцсийн нийт авлагын 54.4 хувийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 44.4 хувийг ЗДТГ-ын авлага, 1.3 хувийг ОНХС-ийн авлага эзэлж байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 91,368.3 мянга, эцсийн үлдэгдэл 127,236.8 мянган төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 35,868.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 47,877.2 | 44,477.2 | (3,400.0) | 35.0 |
| Бичиг хэргийн материал | 978.7 | 859.7 | (119.0) | 0.7 |
| Аж ахуйн материал | 2,698.8 | 4,056.9 | 1,358.1 | 3.2 |
| Түлш, шатах тослох материал | - | 1,705.2 | 1,705.2 | 1.3 |
| Барилгын засварын материал | 4,000.0 | 4,000.0 | - | 3.1 |
| Бусад хангамжийн материал | 13,422.3 | 46,091.4 | 32,669.2 | 36.2 |
| Биологийн хөрөнгө | 15,800.0 | 19,455.0 | 3,655.0 | 15.3 |
| Мал амьтад | 6,591.3 | 6,591.3 | - | 5.2 |
| Дүн | 91,368.3 | 127,236.8 | 35,868.5 | 100.0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын эцсийн үлдэгдлийн 36,9 хувийг бусад хангамжийн материал эзэлж байгаа нь сумын ЗДТГ-ын бараа материал байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ФОРЧИЛТ... САНАЛ ДҮГНЭЛТ

Нийт бараа материалын 95.2 хувийг сумын ЗДТГ-ын, 4.8 хувийг сумын ИТХ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй бараа материал эзэлж байна.

*Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

| № | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ | 85,164.1 | 121,151.6 | 35,987.5 | 95.2 |
| 2 | ИТХ | 6,204.2 | 6,085.2 | (119.0) | 4.8 |
| | ДҮН | 91,368.3 | 127,236.8 | 35,868.5 | 100.0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 348,232.3 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 166,558.6 мянган төгрөгийн бараа материал бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжиж авч, үйл ажиллагаанд 315,397.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,110,570.4 мянга, эцсийн үлдэгдэл 2,397,024.6 мянган төгрөг болж, 286,454.2 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 874,516.84 | 874,516.84 | - | 36.5 |
| Тээврийн хэрэгсэл | 162,094.80 | 195,842.58 | 33,747.8 | 8.2 |
| Машин тоног төхөөрөмж | 304,334.99 | 350,713.49 | 46,378.5 | 14.6 |
| Тавилга эд хогшил | 40,453.33 | 53,940.83 | 13,487.5 | 2.3 |
| Бусад үндсэн хөрөнгө | 689,471.45 | 882,311.89 | 192,840.4 | 36.8 |
| Ном | 1,135.00 | 1,135.00 | - | 0.0 |
| Программ хангамж | 2,300.00 | 2,300.00 | - | 0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 36,264.00 | 36,264.00 | - | 1.5 |
| Дүн | 2,110,570.4 | 2,397,024.6 | 286,454.2 | 100.0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 50,473.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 170,840.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 64,293.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагаас шилжүүлэн авсан, тайлант онд хасагдсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

*Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

| № | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ | 2,070,238.9 | 43,926.0 | (2,026,312.9) | 1.8 |
| 2 | ИТХ | 40,331.5 | 2,353,098.6 | 2,312,767.1 | 98.2 |
| | ДҮН | 2,110,570.4 | 2,397,024.6 | 286,454.2 | 100.0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.4.5 Өр төлбөр

Оны эхэнд өр төлбөргүй, тайлант оны эцэст сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 32,154.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлснийг оны эцэст татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөгөөр бүртгэсэн байна.

*Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| № | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Үүнээс: Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | Үүнээс: Байгууллагад төлөх өглөг | Үүнээс: Бараа үйлчилгээний зардлын өглөг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ | 0 | 32,154.7 | 32,154.7 | 0 | 0 |
| | ДҮН | 0 | 32,154.7 | 32,154.7 | 0 | 0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТ ... САНАЛ ... 005

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,471,999.1 мянга, эцсийн үлдэгдэл 2,439,730.3 мянган төгрөг болж, 32,268.7 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 544,528.1 | 544,528.1 | - | 22.3 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,607,541.1 | 1,575,272.4 | (32,268.7) | 64.6 |
| Өмнөх үеийн үр дүн | 1,441,913.3 | 1,600,500.1 | 158,586.8 | |
| Тайлант үеийн үр дүн | 165,627.8 | (25,227.7) | (190,855.5) | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 319,929.9 | 319,929.9 | - | 13.1 |
| Дүн | 2,471,999.1 | 2,439,730.3 | (32,268.7) | 100.0 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Заг сумын ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 02/23 дугаар тогтоолоор сумын Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан, нас нэг 7,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээл, 41.0 мянган төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг хүчингүй болгож, санхүүгийн тайлангаас хассанаас шалтгаалж, өмнөх үеийн үр дүн данс 7,041.0 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.4.7 Орлогын данс

Заг сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 17/05 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 273,690.0 мянга, татварын бус торгуулийн орлогыг 5,000.0 мянган, нийт 278,690.0 мянган төгрөгөөр баталсныг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01/07 дугаар тогтоолоор татварын орлогыг 305,290.0 мянга, хүү, торгуулийн орлогыг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр татварын орлогыг 310,290.0 мянган төгрөгөөр баталжээ.

*Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 305,290.00 | 403,227.16 | -97,937.16 | 132.1 |
| 110 | Орлогын албан татвар | 282,100.00 | 355,930.93 | -73,830.93 | 126.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 282,100.00 | 355,930.93 | -73,830.93 | 126.2 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 175,000.00 | 215,847.93 | -40,847.93 | 123.3 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 81,000.00 | 111,928.91 | -30,928.91 | 138.2 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 23,100.00 | 26,720.48 | -3,620.48 | 115.7 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 3,000.00 | 1,433.60 | 1,566.40 | 47.8 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 5,190.00 | 17,217.82 | -12,027.82 | 331.7 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,800.00 | 1,854.22 | -54.22 | 103.0 |
| 113002 | Бууны албан татвар | 3,390.00 | 3,510.00 | -120.00 | 103.5 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 0 | 11,853.60 | -11,853.60 | |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 18,000.00 | 30,078.41 | -12,078.41 | 167.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 14,000.00 | 3,108.39 | 10,891.61 | 22.2 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,000.00 | 858.19 | 141.81 | 85.8 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 1,000.00 | 1,000.00 | 0 | 100.0 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 12,000.00 | 1,250.20 | 10,749.80 | 10.4 |
| 1181 | Газрын төлбөр | 4,000.00 | 6,090.02 | -2,090.02 | 152.3 |
| 118101 | Газрын төлбөр | 1,600.00 | 1,664.97 | -64.97 | 104.1 |
| 118102 | Дуудлага худалдаа | 2,400.00 | 4,425.05 | -2,025.05 | 184.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 0 | 20,880.00 | -20,880.00 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 0 | 20,880.00 | -20,880.00 | |
| 120003 | Торгуулийн орлого | 5,000.00 | 3,207.50 | 1,792.50 | 64.2 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 132.1 хувь буюу 97,937.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн хэдий ч зарим татварын орлого тасарсан байна. Иймд татварын орлогыг нэр төрөл тус бүрд биелүүлж ажиллах зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг сумын ИТХ батлахдаа сумын ЗДТГ өөрийн орлогоор 1,000.0 мянга, Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 27,000.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр сумын ЗДТГ орлогоор 230.0 мянган төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөөг 770.0 мянган төгрөгөөр биелүүлээгүй, хоршоо хөгжүүлэх сан гүйцэтгэлээр 31,403.9 мянган төгрөгийг оруулсан байна.

*Хүснэгт 12. Өөрийн орлого /мянган төгрөгөөр/*

| № | Сумын нэр | Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Өөрийн орлогын эх үүсвэрийн талаар тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Заг | ЗДТГ | 1,000.0 | 230.0 | (770.0) | 23% | буудлын төлбөр |
| 2 | Заг | Сум хөгжүүлэх сан | 27,000.0 | 31,403.9 | 4,403.9 | 116% | Зээлийн хүү, эргэн төлөлт |
| | | Дүн | 28,000.0 | 31,633.9 | 3,633.9 | | |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,067,123.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,793,912.3 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,397,000.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 396,912.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан ба байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 321,459.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Заг сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж хүргүүлсэн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 17/05 дугаар тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 1,972,641.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дээрх баталсан анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01/07 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, татварын орлогыг 31,600.0 мянга, урьд оны үлдэгдлийг 136,404.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 73,522.5 мянган төгрөгөөр бууруулан, тодотгосон төсвийг 2,067,123.4 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 13. Заг сумын Засаг даргын 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Анхны баталсан 2023.12.19-ний өдрийн 17/05 тогтоол | Сумын ИТХ-ын 2024.10.28-ны өдрийн 01/07 тогтоол | Өөрчлөлт | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Татварын орлого | 273,690.00 | 305,290.00 | 31,600.00 | 18.4 |
| 2 | Татварын бус орлого /торгуулийн орлого/ | 5,000.00 | 5,000.00 | 0.00 | 0.3 |
| 3 | Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 979,363.20 | 905,840.70 | -73,522.50 | 24 |
| 4 | Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг | 225,190.10 | 225190.1 | 0.00 | 24.8 |
| 5 | Өөрийн орлого ЗДТГ | 1,000.00 | 1,000.00 | 0.00 | 0 |
| 6 | Өөрийн орлого Хоршоо хөгжүүлэх сан | 27,000.00 | 27,000.00 | 0.00 | 2.7 |
| 7 | Сумын төсвийн урьд оны үлдэгдэл | 347,491.00 | 460893.2 | 113,402.20 | 18.5 |
| 8 | Сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл | 50,907.40 | 73,909.40 | 23,002.00 | 9.2 |
| 9 | Сумын хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл | 63,000.00 | 63,000.00 | 0.00 | 2.2 |
| | ДҮН | 1,972,641.70 | 2,067,123.40 | 94,481.70 | 100 |

*Эх сурвалж. Заг сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 17/05, 2024 оны 01/07 дугаар тогтоол*

Заг сумын төсөвт байгууллагууд оны эцэст зардлын хэмнэлтийн 116,095.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлсэн ба нийт баталсан зардлын 86.8 хувийг гүйцэтгэлээр зарцуулжээ.

*Хүснэгт 14. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

| № | Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОНТ-т төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ | 1,189,814.40 | 1,090,135.70 | 99,678.70 | 91.6 | 98,908.70 |
| 2 | ИТХ | 178,017.20 | 166,842.10 | 11,175.10 | 93.7 | 11,175.1 |
| 3 | ЕБС | 134,809.20 | 134,805.70 | 3.50 | 100.0 | 3.40 |
| 4 | Цэцэрлэг | 38,606.00 | 38,256.80 | 349.20 | 99.1 | 454.00 |
| 5 | ЭМТ | 61,587.20 | 59,233.20 | 2,354.00 | 96.2 | 2,354.00 |
| 6 | Соёлын төв | 75,189.90 | 71,989.10 | 3,200.80 | 95.7 | 3,200.70 |
| 7 | ОНХС | 299,099.50 | 182,499.70 | 116,599.80 | 61.0 | 0 |
| 8 | Хоршоо хөгжүүлэх сан | 90,000.00 | 50,150.00 | 39,850.00 | 55.7 | - |
| | ДҮН | 2,067,123.40 | 1,793,912.30 | 273,211.10 | 86.8 | 116,095.90 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 86.8 хувьтай байгаа нь сумын ЗДТГ баталсан орон тоогоор дутуу ажилласнаас цалингийн зардлыг 12,887.7 мянган төгрөгийг хэмнэсэн, хог хаягдлын машин эвдэрч ажилтан ажиллуулаагүйгээс хог хаягдал зайлуулах зардлыг 6,444.2 мянга, бараа үйлчилгээний зардлыг 44,783.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 22,055.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Заг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 232,713.2 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 10,466.3 мянга, нийт 243,179.5 мянган төгрөгийн санхүүжилт орсноос бараа үйлчилгээний бусад зардалд 211,024.8 мянган төгрөгийг зарцуулан, ЗДТГ хэмнэлтийн 32,154.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САН... ...НТ

Тайлант онд сумын Засаг даргын харьяаны байгууллагууд тавьсан зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 15. Хүрэх үр дүнгийн биелэлт /мянган төгрөгөөр/*

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт | | | 2024оны зорилтот түвшин | 2024 онд хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 | 7 |
| ЗАГ СУМ | | | | | | 2,067,123.40 | 1,793,913.30 |
| 1 | 70105 | Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | Сумын ИТХ-ын үйл ажиллагаа | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн хөгжлийн бодлого тодорхойлох чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангаж ажиллах. Хурлын хуралдааныг улирал тутам хуралдаж шийдвэр гаргана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг хийнэ. Зөвлөл, хороодын хуралдааныг тухай бүр хуралдаж зөвлөмж гаргана. | Тайлант онд ИТХ-ын ээлжит хуралдааныг 4 удаа, ээлжит бус хуралдааныг 2 удаа нийт 8 удаагийн хуралдааныг зохион байгуулж сумын эдийн засаг нийгмийн хөгжлийг тодорхойлсон. Багийн Иргэдийн Нийтийн хурлыг баг тус бүр дээр 2 удаа нийт удаа хийсэн. | 178,017.20 | 166,842.10 |
| 2 | 70106 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, ард иргэдэд төрийн бодлого шийдвэрийг хүргэх, Засаг захиргааны анхан шатны нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх,иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмж үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого төлөвлөлтийг зохион байгуулах | Аймгийн ИТХ-ын 9 тогтоолыг 80.3 хувьтай, аймгийн Засаг даргын 116 захирамжийг95 хувьтай, Засгийн газрын 88 тогтоол, шийдвэрийг 83.5 хувьтай тус тус биелүүлсэн байна. | 1,189,814.40 | 1,090,135.70 |
| 3 | 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн. | 61,587.20 | 59,233.20 |
| 4 | 71702 | Соёл урлаг | Соёл урлаг | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн. | 75,189.90 | 71,989.10 |
| 5 | 71801 | Сургуулийн өмнөх боловсрол | Сургуулийн өмнөх боловсрол | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн. | 38,606.00 | 38,256.80 |
| 6 | 71802 | Ерөнхий боловсрол | Ерөнхий боловсрол | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Байгууллагын тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлсэн | 134,809.20 | 134,805.70 |
| 6 | 72101 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | Хоршоо хөгжүүлэх сан | Хоршоо хөгжүүлэх сангаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох, бодлогоор дэмжих | Сумын жижиг дунд үйлдвэрлэл, хоршоодын хөгжлийг дэмжих зорилгоор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 50.0 сая төгрөгийн зээл олгосон | 90,000.00 | 50,150.00 |
| | 70503 | орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт | Орон нутгийн хөгжлийн сан, Их засварын арга хэмжээ | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөх, бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтыг нэмэгдүүлэх | Хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай ашиглах, хууль тогтоомж, журам зааврын хүрээнд төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. | 299,099.50 | 182,499.70 |

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын харьяа байгууллагуудын биелэлт, санхүүгийн тайлан*

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Заг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025.03.06-ны өдөр ирүүлсэн байна.

Заг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга Т.Нямжаргал, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга Д.Дуламсүрэн нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны баталсан төсөв 2,067,123.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 20,671.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 13,436.3 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Заг сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар дараах зардлуудыг хэмнэсэн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг хэрэгжүүлж, оны эхэнд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 306,097.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 бараа, ажлуудын тендерийг дээрх заасан хугацаанд зохион байгуулсан.

- Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ЗДТГ байгаль орчны байцаагч 1, хөдөө аж ахуйн тасгийн 1 мэргэжилтэн, нийт 2 орон тоо дутуу ажилласантай холбоотой цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг хэмнэж, хэмнэлтийг бусад зарцуулаагүй байна.

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан, Заг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар тус хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Заг сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2024 онд нийт 12 төрлийн 89 мэдээлэл оруулахаас мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Заг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд ахлах аудитор Б.Азбаяр, ИТХ болон тусгай сангуудын санхүүгийн тайланд аудитор Д.Цэдэвцэвээн нар завсрын аудитыг 2024 оны 12 дугаар сард гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар илэрсэн дээрх зөрчлийг төсөвт байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд залруулж арга хэмжээг авч ажилласан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Заг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Наранцэцэг аудит хийж, албан татварыг орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх, дотоод хяналт хариуцлагыг сайжруулах 2 зөвлөмжийг өгсөн байна. Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу сумын ЗДТГ-ын даргаар "Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г гаргаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 1/92 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

005 ТӨРИЙН АУДИТЫН ... ГАЗАР ... САНА...

## 4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Заг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ ИТХ болон 2 тусгай сангийн санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдаж, сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Заг сумын Засаг даргын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд нийт 23,252.9 мянган төгрөгийн 7 алдаа[1] илэрснээс аудитын явцад алдаа, зөрчил илэрсэн, харин тусгай сангуудад зөрчил илрээгүй байна.

*Хүснэгт 18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/*

| № | Байгууллагын нэр | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | Зөрчлийн ангилал |
|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 6 |
| 1 | Заг сумын ЗДТГ | ЭМНДШ-д 1,871.9 мянган төгрөгийн цалинг илүү мэдээлж, түүнд ногдох 441.2 мянган төгрөгийн шимтгэл илүү төлсөн байна. | 441.2 | Төлбөрийн акт тогтоосон | Санхүүгийн аудит |
| 2 | Заг сумын ЗДТГ | Эд хариуцагчийн тайланг шалгаж үзэхэд Бичиг хэрэгийн тайлан 1,838.3 мянган төгрөгийн орлого, 192.5 мянган төгрөгийн зарлага, Шатахууны тайлан 1,075.1 мянган төгрөгийн зөрүүтэй байна. | 3,105.9 | Албан шаардлага өгсөн | Санхүүгийн аудит |
| | | ДҮН | 3,547.1 | | |
| 1 | Заг сумын ИТХ | Сумын ИТХ-ын даргын 2024 оны А/10 дугаар захирамжаар ИТХ-ын төлөөлөгч нарт тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардал тус бүр 770.0 мянган төгрөг нийт 14,000.0 мянган төгрөг данс руу нь шилжүүлсэн ба зарцуулалтын тайлан холбогдох анхан шатны баримт байхгүй байна | 14,000.0 | Албан шаардлага өгсөн | Санхүүгийн аудит |
| 2 | Заг сумын ИТХ | ИТХ-ын хуралдааны зардлаас 2024.10.29-ны өдөр 527.3 мянган төгрөгийг Б.Ганцэцэгийн данс руу ХХОАТ суутган шилжүүлсэн ба ямар нэгэн тушаал шийдвэр, холбогдох материал, анхан шатны баримт байхгүй байна. | 527.3 | Албан шаардлага өгсөн | Санхүүгийн аудит |
| 3 | Заг сумын ИТХ | ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар иргэн М.Отгонтуяад сумын хэмжээнд ашиглаж байгаа замын тэмдэглэгээ сэргээн засварласан хөлс болох 217.0 мянган төгрөг олгосон ба ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, ажлыг дүгнэсэн нотлох баримт байхгүй иргэний гаргасан өргөдлийг үндэслэн олгосон байна. | 217.0 | Төлбөрийн акт тогтоосон | Санхүүгийн аудит |
| 4 | Заг сумын ИТХ | ИТХ-ын хуралдааны зардлаар авсан үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа нийт 4,961.5 мянган төгрөгийн холбогдох материал /нэг удаагийн аяга, халбага, кофе, гарын авлага/-ыг бараа материалын тайланд орлого авахгүй шууд зарлагаар гаргасан байна. | 4,961.50 | Зөвлөмж өгсөн | Санхүүгийн аудит |
| 5 | Заг сумын ИТХ | Нийгмийн даатгалын мэдээг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 109.0 мянган, даатгуулагчаас төлөх 13.3 мянган төгрөг нийт 122.4 мянган төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байна. | 122.40 | Санхүүгийн тайланд залруулсан | Санхүүгийн аудит |
| | | ДҮН | 19,828.20 | | |
| | | НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН | 23,375.3 | | |

*Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл*

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэлээгүй орхисон/,*

Аудитаар нийт 23,375.3 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил[2] илэрснээс, 122.4 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 658.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 17,633.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгч, 4,961.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

## Аудитын илрүүлэлт

Аудитаар орон нутгийн төсвийг бүрдүүлж байгаа татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй зөрчил илэрсэнд зөвлөмжийг хүргүүлэв.

## 5.1. ЗӨВЛӨМЖ

1. Заг сумын төсөвт төвлөрөх хог хаягдлын үйлчилгээний хураамжаар 2024 онд 12,000.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,250.2 мянган төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөөг 10,749.8 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх “Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Иймд хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг батлуулж, баталсан татварын орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын системд оруулж, биелэлтийг нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн албаны даргад талархал илэрхийлье.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Заг сумын төсөвт төвлөрөх хог хаягдлын үйлчилгээний хураамжаар 2024 онд 12,000.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,250.2 мянган төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөөг 10,749.8 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна. | 1 | 10,749.8 | | | | | 1 | 10,749.8 |
| Дүн | 1 | 10,749.8 | 0 | - | 0 | - | 1 | 10749.8 |

---oOo---

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*